



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/080/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор Б.Бадамцэцэг Утас:99062042 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № А13
танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Д.ДАВААДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд соёлын төвийг бүрэн камержуулан, лед дэлгэц суурилуулан давхардсан тоогоор 11200 иргэнд соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

A4-тоот-2026

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	161,522.20	282,034.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	161,522.20	282,034.57
34600	Урьдчилж гарсан зардал	620,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,473,703.22	22,924,507.62
354	Хангамжийн материал	25,473,703.22	22,924,507.62
35410	Бичиг хэргийн материал	474,997.00	172,000.00
35420	Аж ахуйн материал	20,448,956.22	17,944,957.62
35450	Барилгын засварын материал	65,000.00	65,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,484,750.00	4,742,550.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,255,225.42	23,206,542.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	639,624,065.33	606,803,065.98
392	Биет хөрөнгө	620,605,798.61	588,734,799.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	558,811,686.00	560,834,486.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,437,402.56	-84,468,636.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,045,020.00	155,587,276.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,553,323.76	-68,950,516.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,034,048.00	37,234,088.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,652,133.07	-27,859,802.47
39217	Ном	16,357,904.00	16,357,904.00
393	Биет бус хөрөнгө	19,018,266.72	18,068,266.80
39301	Програм хангамж	4,750,000.00	4,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,447,733.28	-2,397,733.20
39303	Бусад биет бус хөрөнгө	15,716,000.00	15,716,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	639,624,065.33	606,803,065.98
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	665,879,290.75	630,009,608.17
51	Засгийн газрын хувь оролцоо	665,879,290.75	630,009,608.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	398,566,048.00	398,566,048.00
51101	Өмч: - төрийн	398,566,048.00	398,566,048.00
512	Хуримтлагдсан үр дүн	27,738,579.75	-8,131,102.83
51210	Өмнөх үеийн үр дүн	-60,548,359.33	29,743,039.75
51220	Тайлант үеийн үр дүн	88,286,939.08	-37,874,142.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,574,663.00	239,574,663.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	665,879,290.75	630,009,608.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	665,879,290.75	630,009,608.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	246,212,100.58	223,509,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212,605,100.58	177,721,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,605,100.58	177,721,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,607,000.00	45,788,800.00

**Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,607,000.00	45,788,800.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	94,423,059.00	5,373,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,423,059.00	5,373,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,686,500.00	2,626,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,686,500.00	2,626,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	91,736,559.00	2,747,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	340,635,159.58	228,883,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,348,220.50	266,592,342.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,855,174.11	262,590,480.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,388,695.99	148,241,546.55
210101	Үндсэн цалин	87,546,729.64	94,403,471.82
210102	Нэмэгдэл	30,804,086.35	47,808,841.09
210104	Урамшуулал	15,037,880.00	6,029,233.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,342,051.01	18,338,927.34
210201	Тэтгэврийн даатгал	11,338,039.16	12,684,456.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,292,002.97	1,405,554.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	703,363.48	1,307,616.01
210204	Ажилгүйдлийн даатгал	584,975.48	558,467.91
210205	Эрүүл мэндийн даатгал	2,423,669.92	2,382,831.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,551,692.90	43,173,111.39
210301	Гэрэл, цахилгаан	859,492.90	1,220,153.39
210302	Түлш, халаалт	30,492,200.00	41,922,958.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,177,570.00	10,026,595.60
210401	Бичиг хэрэг	1,229,500.00	1,740,997.00
210402	Тээвэр, шатахуун	2,046,430.00	1,875,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	776,540.00	879,000.00
210404	Ном, хэвлэл	566,500.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	373,100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	185,500.00	5,530,698.60
2105	Нормативт зардал	195,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	195,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,637,000.00	150,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,837,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	1,479,900.00	470,000.00
210702	Дотоод албан томилолт	1,479,900.00	470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,540,200.00	1,220,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,140,250.00	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,399,950.00	620,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,543,064.21	40,970,299.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,643,000.00	4,265,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,900,064.21	36,705,299.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,493,046.39	4,001,862.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,516,000.00	620,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,178,700.00	620,000.00

**Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,557,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,721,739.29	2,366,173.74
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	4,721,739.29	2,366,173.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,255,307.10	1,015,688.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,255,307.10	1,015,688.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	252,348,220.50	266,592,342.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,286,939.08	-37,708,642.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	165,500.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	165,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-165,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,286,939.08	-37,874,142.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	246,212,100.58	223,509,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	212,605,100.58	177,721,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,605,100.58	177,721,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,607,000.00	45,788,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,607,000.00	45,788,800.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	2,686,500.00	2,626,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,686,500.00	2,626,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,686,500.00	2,626,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,686,500.00	2,626,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	248,898,600.58	226,135,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,867,978.49	224,108,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,374,932.10	220,107,037.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,868,069.20	145,713,922.66
210101	Үндсэн цалин	74,979,346.58	86,523,568.30
210102	Нэмэгдэл	40,692,517.62	50,890,254.36
210104	Урамшуулал	17,196,205.00	8,300,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,024,200.00	18,257,603.60
210201	Тэтгэврийн даатгал	11,576,500.00	12,378,303.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,362,000.00	1,469,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	680,900.00	734,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	680,900.00	734,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,723,900.00	2,939,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,551,692.90	43,173,111.39
210301	Гэрэл, цахилгаан	859,492.90	1,220,153.39
210302	Түлш, халаалт	30,492,200.00	41,922,958.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,415,340.00	3,033,200.00
210401	Бичиг хэрэг	1,573,500.00	300,000.00

**Эрдэнэбүрэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	1,457,000.00	1,604,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	776,540.00	879,000.00
210404	Ном, хэвлэл	733,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	458,600.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,700.00	250,200.00
2105	Нормативт зардал	500,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,782,500.00	4,641,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,982,500.00	3,041,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	1,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,479,900.00	470,000.00
210702	Дотоод албан томилолт	1,479,900.00	470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,787,450.00	1,912,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,352,100.00	1,762,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,285,350.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,965,780.00	2,905,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,965,780.00	2,905,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,493,046.39	4,001,862.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,516,000.00	620,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,178,700.00	620,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,557,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,721,739.29	2,366,173.74
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	4,721,739.29	2,366,173.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,255,307.10	1,015,688.61
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,255,307.10	1,015,688.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>241,867,978.49</u>	<u>224,108,900.00</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,030,622.09</u>	<u>2,027,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,721,500.00	2,027,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,721,500.00	2,027,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,721,500.00	2,027,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,721,500.00	2,027,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7,721,500.00</u>	<u>-2,027,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-690,877.91	0.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	690,877.91	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	-60,548,359.33	577,592,351.67
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	-60,548,359.33	577,592,351.67
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	88,286,939.08	88,286,939.08
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	27,738,579.75	665,879,290.75
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	27,738,579.75	665,879,290.75
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,004,460.00	2,004,460.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	29,743,039.75	667,883,750.75
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-37,874,142.58	-37,874,142.58
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,566,048.00	239,574,663.00	-8,131,102.83	630,009,608.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,075,200.00	177,721,100.00
122005	Төсвөөс санхүүжих	181,075,200.00	177,721,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,568,800.00	45,788,800.00
132003	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		45,788,800.00
12000	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	0	2,626,000.00
120010	Туслах үйл ажиллагааны орлого	0	2,626,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	226,644,000.00	226,135,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	226,644,000.00	226,135,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,691,100.00	222,134,037.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,632,800.00	145,713,922.66
210101	Үндсэн цалин	88,569,300.00	86,523,568.30
210102	Нэмэгдэл	49,247,100.00	50,890,254.36
210104	Урамшуулал	8,816,400.00	8,300,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,478,600.00	18,257,603.60
210201	Тэтгэврийн даатгал	12,599,300.00	12,378,303.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,469,800.00	1,469,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	734,900.00	734,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	734,900.00	734,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,939,700.00	2,939,700.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,968,800.00	43,173,111.39
210301	Гэрэл, цахилгаан	1,801,800.00	1,220,153.39
210302	Түлш, халаалт	41,947,000.00	41,922,958.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	30,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,114,200.00	3,033,200.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,604,000.00	1,604,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	879,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	250,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,141,000.00	5,141,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,541,000.00	3,541,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	750,000.00	470,000.00
210702	Дотоод албан томилолт	750,000.00	470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,700,000.00	3,439,500.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	4,550,000.00	3,289,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,905,700.00	2,905,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,905,700.00	2,905,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	952,900.00	4,001,862.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	952,900.00	620,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	952,900.00	620,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	3,381,862.35
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,381,862.35
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	226,644,000.00	226,135,900.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,995.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 602.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант үеийн үр дүн 602.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 5,392.6 мянган төгрөгийн 1 зөрчил нь материаллаг бус зөрчил тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт залруулагдаагүй 5,392.5 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрснээс, 5,392.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Цалин, орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын ОНХСан, хоршоо хөгжлийн сан хариуцсан нягтлан бодогч нь Соёлын төвд нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг, орон нутагт ажилласны нэмэгдлийг тогтоосон хувиас илүү бодож 5,392,604 төгрөгийг бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Эрдэнэбүрэн сумын соёлын төв	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй тусгасан	1	602.8			1	602.8	1	602.8				
	Дүн	1	602.8			1	602.8	1	602.8	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутагт ажилласны нэмэгдлийг ажилчдад илүү хувиар олгосон	1	5,392.6	1	5,392.6					-	-	-	-
Дүн	1	5,392.6	1	5,392.6	-	-	-	-				-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			